



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: У.Батчимэг Утас: 88094175 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 215  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МЯНГАН-УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ИЙН  
ДАРГА Д.ОТГОНТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мянган Угалзат ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 19 дүгээр зүйлийн 1, 20 дугаар зүйлийн 20.1.3 дэх заалтуудтай тус тус нийцээгүй нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулахгүйгээр 203.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 203.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн,
- Өмнөх онуудын 133.3 сая төгрөгийн авлага барагдуулах ажиллах ажил зохион байгуулан ажиллаагүй,
- Тайлант онд 27.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан зөрчил илэрлээ,
- Аудитын шийдвэрхийн хэрэгжилт хангагдаагүй байна,

**Асуудлыг онцолсон хэсэг**

Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь 2025 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад хянуулахаар хүргүүлж баталуулаагүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн дугаар А/141 тушаалаар 30.0 сая төгрөгийн хөрөнгийн өтрөг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Соёл амралтын хүрээлэн буюу Хүүхдийн парк нь жил бүрийн 5 дугаар сараас эхлэн 8 дугаар сарын 31-ныг дуустал 4 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулж байна. Тус газар нь парк дарга, нарийн бичиг, нягтлан бодогч, цахилгааны инженер, хөдөлмөр хамгааллын инженер, зохион байгуулагч, нярав, касс, харуул хамгаалалт, ногоон байгууламжийн ажилтан операторууд зэрэг бүрэлдэхүүнтэй ажиллаж байна

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	28,565.15	29,363.98
1.1.2 Дансны авлага	21,583,502.00	21,583,502.00
1.1.4 Бусад авлага	234,848.00	234,848.00
1.1.6 Бараа материал	25,177,060.00	16,402,860.00
<b>1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>47,023,975.15</b>	<b>38,250,573.98</b>
1.2.1 Үндсэн хөрөнгө	273,786,537.87	281,976,457.83
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө	200,000,000.00	200,000,000.00
<b>1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>473,786,537.87</b>	<b>481,976,457.83</b>
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>520,810,513.02</b>	<b>520,227,031.81</b>
2.1.1.1 Дансны өглөг	20,163,329.96	5,955,927.16
2.1.1.2 Цалингийн өглөг	14,895,793.80	13,479,222.40
2.1.1.3 Татварын өр	77,904,285.12	59,595,331.91
2.1.1.4 НДШ - ийн өглөг	20,378,942.04	41,397,281.21
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>133,342,350.92</b>	<b>120,427,762.68</b>
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр	-	40,741,055.97
<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>40,741,055.97</b>
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>133,342,350.92</b>	<b>161,168,818.65</b>
2.3.1 Өмч:	359,038,700.00	359,038,700.00
2.3.1.1 - төрийн	359,038,700.00	359,038,700.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	257,658,892.07	257,658,892.07
2.3.6 Эздийн өмчийн бусад хэсэг	240,032,900.00	240,032,900.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	-	(469,262,329.97)
алдагдал	(469,262,329.97)	(28,409,948.94)
2.3.9 Эздийн өмчийн дүн	387,468,162.10	359,058,213.16
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>520,810,513.02</b>	<b>520,227,031.81</b>
1 Актив	520,810,513.02	520,227,031.81
2 Пассив	520,810,513.02	520,227,031.81

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	2. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1. Борлуулалтын орлого (цэвэр)	164,004,259.81	185,296,146.43
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	202,779,690.64	197,170,475.37
3. Нийт ашиг ( алдагдал)	(38,775,430.83)	(11,874,328.94)
10. Ерөнхий ба удирдлагын зардал	5,889,892.69	16,535,620.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(44,665,323.52)	(28,409,948.94)
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(44,665,323.52)	(28,409,948.94)
22. Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	(44,665,323.52)	(28,409,948.94)
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(44,665,323.52)	(28,409,948.94)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>180,404,634.18</b>	<b>203,825,776.12</b>
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	164,004,259.73	185,296,146.43
1.1.6 Бусад мөнгөн орлого	16,400,374.45	18,529,629.69
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>180,561,872.52</b>	<b>203,824,977.29</b>
1.2.1 Ажиллагчдад төлсөн	113,275,863.62	136,972,556.50
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,720,938.13	6,400,835.00
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	19,796,400.00	13,105,927.00
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	2,979,019.49	7,497,181.00
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	34,112,000.00
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	-	2,419,069.14
1.2.9 Бусад мөнгөн зарлага	10,789,651.28	3,317,408.65
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(157,238.34)</b>	<b>798.83</b>
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(157,238.34)	798.83
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	185,803.49	28,565.15
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,565.15	29,363.98
<b>1 БЦМГ /1,3+2,3+3,3+4/</b>	<b>(157,238.34)</b>	<b>798.83</b>
<b>2 БЦМГ /6-5/</b>	<b>(157,238.34)</b>	<b>798.83</b>

## 2.4 Аудит хийсэн өмч өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
Залруулсан үлдэгдэл	359,038,700	257,658,892.07	240,032,900	(424,597,006.45)	432,133,485.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(44,665,323.52)	(44,665,323.52)
Эхний үлдэгдэл	359,038,700	257,658,892.07	240,032,900	(469,262,329.97)	387,468,162.10
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
10. Залруулсан үлдэгдэл	359,038,700	257,658,892.07	240,032,900	(469,262,329.97)	387,468,162.10
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(28,409,948.94)	(28,409,948.94)
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	359,038,700	257,658,892.07	240,032,900	(497,672,278.91)	359,058,213.16

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 203,827.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 3.1.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тус газар нь 2025 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад хянуулахаар хүргүүлж баталуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг ханган гэсэн заалтуудтай нийцээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээд шатны байгууллагаар Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллах

##### 3.1.2 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим сайтад 5 саяаас дээш орлогын гүйлгээ, Хандив, тусламжийн орлого, Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан, Хавсралт файлууд, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байршуулаагүй, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 -д Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/. 6.3.5.хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** shilendans.gov.mn цахим системд Өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрүүдийг бүрэн мэдээлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Мянган-Угалзат ОНӨААТҮГ	2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулаагүй байна.	1	203,827.7					1	203,827.7		
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>203,827.7</b>			-	-	<b>1</b>	<b>203,827.7</b>		

##### 4.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Мянган-Угалзат ОНӨААТҮГ	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй	1							1	
<b>Нийт дүн</b>		<b>1</b>							<b>1</b>	

#### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨААТҮГ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		